

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/92/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас:261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор П.Амарсанаа
Утас:261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Солид Юнити Аудит ХХК-ийн захирал Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УЦС	Усан цахилгаан станц



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

0006.03.16 № 06/650
танай _____-ны № _____-т

ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ
М.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Эрчим хүчний сайдын багцаас үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 770.3 сая төгрөгийн санхүүжилт авч, техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт судалгааны ажлын гэрээний дагуу 519.9 сая төгрөгийн хөрөнгийг эрчим хүчний яамнаас балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын “Эгийн голын усан цахилгаан станцын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх” 2025 оны 172 дугаар тогтоолоор судалгааны ажлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн, 2025 оны баталсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг үүрэг болгосны дагуу томоохон 3 судалгааны ажил хийгдэж байна. Үүнд:

1. Төрийн худалдан авах ажиллагааны газраас нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж, Эдийн засаг, хөгжлийн яамны санхүүжилтээр хийгдэж буй “Эгийн голын усан цахилгаан станцын туслах боомтын ТЭЗҮ болон үндсэн ТЭЗҮ-ийг тодотгох нэмэлт судалгаа”-ны ажил,
2. Дэлхийн өвийн хорооны 46 дугаар чуулганы шийдвэрийн дагуу “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны аргачлал болон олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхээр төлөвлөж, Эрчим хүчний яам гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн ба уг судалгааны ажил
3. “Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрний экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгаа”-ны ажил хийгдэж байна. Уг судалгаагаар Эгийн голын УЦС төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн судалгаа, үнэлгээний ажилд ОХУ-ын талаас ирүүлсэн санал, шүүмжийг авч үзэх, ОХУ-ын талтай Эгийн голын УЦС төслийг хэрэгжүүлэх тал дээр нэгдсэн ойлголцолд хүрэх юм. Хоёр улсын Байгаль орчны сайд нарын байгуулсан санамж бичгийн хүрээнд хоёр улсын эрдэмтэн судлаачдын хамтарсан дүгнэлтийг улирал бүр хийсэн хээрийн хэмжилт судалгаа болон тэдгээрийн дүн шинжилгээнд үндэслэж боловсруулах бөгөөд уг дүгнэлтийг Монгол Улс, ОХУ-ын засгийн газар хоорондын комисс-т 2026 оны 2 дугаар улиралд танилцуулахаар талууд харилцан тохиролцсон.

Бусад асуудлын хэсэг

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 02 дугаар тогтоолоор “Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК”-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж нийт хувьцааны 66 хувь буюу 132 ширхэг хувьцааг Эрчим хүчний яам, 34 хувь буюу 68 ширхэг хувьцааг Эрчимт монгол ХХК эзэмшиж байна. Үүнтэй холбоотой компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Тус компани нь тайлант жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 үндсэн зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан.

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	95,868,329.23	100,609,880.53
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	23,107,035.02	50,253,161.36
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	5,280,323.37	2,286,042.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	124,255,687.62	153,149,083.89
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	82,068,680.40	566,661,848.57
1.2.2	Биет бус хөрөнгө	35,119,613,112.11	18,639,375,392.55
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	16,475,455,692.55
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	35,201,681,792.51	35,681,492,933.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	35,325,937,480.13	35,834,642,017.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	92,718,000.00	92,718,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,231,989.00	69,550,459.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	93,949,989.00	162,268,459.50
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	60,616,754,341.97	60,616,754,341.97
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	450,894,109.50
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	60,616,754,341.97	61,067,648,451.47
2.2	Өр төлбөрийн нийт дүн	60,710,704,330.97	61,229,916,910.97
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	20,000.00	20,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,635,520,000.00	18,635,520,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(44,020,306,850.84)	(44,030,814,893.41)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(25,384,766,850.84)	(25,395,274,893.41)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	35,325,937,480.13	35,834,642,017.56

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	3,250,440.00	2,437,830.00
5	Хүүгийн орлого	1,443,084.99	2,842,529.08
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	760,247,215.00	771,251,075.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	632,973,925.50	786,797,245.97
11	Санхүүгийн зардал	1,242,151,445.58	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	611,122,354.09	42,022.23
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(499,062,277.00)	(10,223,789.66)
19	Орлогын татварын зардал	-	284,252.91
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(499,062,277.00)	(10,508,042.57)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(499,062,277.00)	(10,508,042.57)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(499,062,277.00)	(10,508,042.57)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(43,530,944,573.84)	(24,895,404,573.84)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	9,700,000.00	9,700,000.00
3	Залруулсан үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(43,521,244,573.84)	(24,885,704,573.84)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(499,062,277.00)	(499,062,277.00)
5	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(44,020,306,850.84)	(25,384,766,850.84)
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
7	Залруулсан үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(44,020,306,850.84)	(25,384,766,850.84)
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(10,508,042.57)	(10,508,042.57)
9	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(44,030,814,893.41)	(25,395,274,893.41)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	847,321,576.33	776,442,106.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	837,938,830.00	770,299,194.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,382,746.33	6,142,912.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	772,316,814.02	749,965,626.01
1.2.1	Ажиллагчдад төлсөн	307,328,079.22	381,867,301.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	95,030,551.76	89,341,329.70
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	157,116,997.00	14,587,300.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,200,000.00	4,200,000.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	45,322,047.61	42,682,760.87
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	163,319,138.43	217,286,934.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	75,004,762.31	26,476,479.99
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,443,084.99	2,842,529.08
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,443,084.99	2,842,529.08
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	73,588,605.00	24,619,480.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	73,588,605.00	24,619,480.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(72,145,520.01)	(21,776,950.92)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	(417,540.53)	42,022.23
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,441,701.77	4,741,551.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	93,426,627.46	95,868,329.23
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,868,329.23	100,609,880.53

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		2025гүйц/2025төл	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	мянган төг	764,940.7	1,262,600.0	776,573.4	(486,026.6)	(38.5%)
Борлуулалтын орлого	мянган төг	-	-	-	-	-
Улсын төсвийн санхүүжилт	мянган төг	760,247.2	1,259,300.0	770,299.2	(489,000.8)	(38.8%)
Үйл ажиллагааны бус орлого	мянган төг	4,693.5	3,300.0	6,274.2	2,974.2	90.1%
Нийт зардал	мянган төг	1,264,002.9	1,151,300.0	786,797.2	(364,502.8)	(31.7%)
Үндсэн үйл ажиллагааны зардал	мянган төг	591,648.7	1,151,300.0	786,797.2	(364,502.8)	(31.7%)
Элэгдэл	мянган төг	41,325.1	34,000.0	46,871.6	12,871.6	37.9%
Бусад тогтмол	мянган төг	(611,122.3)	1,117,300.0	739,925.6	(377,374.4)	(33.8%)
Үйл ажиллагааны бус зардал	мянган төг	1,242,151.4	-	-	-	-
Татварын өмнөх ашиг /алдагдал/	мянган төг	(499,062.2)	111,300.0	(10,223.8)	(121,523.8)	(109.2%)
Орлогын татварын зардал	мянган төг	-	-	284.2	284.2	100.0%
Татварын дараах ашиг /алдагдал/	мянган төг	(499,062.2)	111,300.0	(10,508.0)	(121,808.0)	(109.4%)
Нийт авлага	мянган төг	-	-	-	-	-
Нийт өглөг	мянган төг	60,710,704.2	36,200,000.0	61,229,916.9	25,029,916.9	69.1%
Богино хугацаат өр төлбөр	мянган төг	93,949.9	-	162,268.5	162,268.5	100.0%
Урт хугацаат өр төлбөр	мянган төг	60,616,754.3	36,200,000.0	61,067,648.4	24,867,648.4	68.7%
Нийт ажиллагсад	тоо	9.0	11	10	(1.0)	(9.1%)
Нийт цалингийн сан	мянган төг	362,384.5	574,500.0	444,742.6	(129,757.4)	(22.6%)
Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө	мянган төг	60,721.7	24,490.0	24,619.5	129.5	0.5%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар 1991 онд Эгийн голын усан цахилгаан станцыг барих шийдвэрийг анх гаргаснаас хойш 2014 онд 315 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 117 дугаар тогтоолоор тус төслийг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийг байгуулсан.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн эрхэм зорилгыг “Эгийн голын усан цахилгаан станц барих төслийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлж, түлхүүр гардуулах нөхцөлөөр станцыг барьж ашиглалтад оруулснаар Монгол Улсын эрчим хүчний системийн бие даасан байдлыг ханган, аваарын болон нөөцийн хүчин чадлыг бий болгож системийн тогтвортой, аюулгүй ажиллагааг нь дээшлүүлэх, оргил ачааллын горим тохируулгын найдвартай ажиллагааг бүрэн хангахад оршино” гэж тодорхойлжээ.

Компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бусад техникийн баримт бичгийг боловсруулах;
- Байгал орчин, нийгмийн нөлөөллийн болон бусад судалгааны ажлыг хийж гүйцэтгэх;
- Санхүүгийн нөхцөлийг тодорхойлж, шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцуулах;
- Барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;
- Станцын үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн төвийн эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлэх

Эрчим хүчний бие даасан системийг бий болгох, найдвартай ажиллагааг хангах, цэвэр усны нөөц бүрдүүлэх, үр ашигтай, хариуцлагатай, тогтвортой байдлаар, улс орны баялаг, орлогыг нэмэгдүүлэхийн тулд Эгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулах зорилгоор судалгааны ажлууд хийгдэж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь Компанийн тухай хууль, Байгал орчны тухай хууль, Усны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компани дотоод хяналтын мэргэжилтэн, нэгжгүй бөгөөд үйл ажиллагааны дотоод хяналтыг ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтод дурдагдсан чиг үүргийн дагуу шат шатны удирдах албан тушаалтан хариуцсан ажилтнуудын ажлыг хянах хэмжээнд гүйцэтгэж байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 508.7 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	95,868.3	100,609.9	4,741.6
Бараа материал	23,107.0	50,253.2	27,146.1
Урьдчилгаа	5,280.3	2,286.0	(2,994.3)
Үндсэн хөрөнгө	82,068.7	566,661.8	484,593.2
Биет бус хөрөнгө	35,119,613.1	18,639,375.4	(16,480,237.7)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	16,475,455.7	16,475,455.7
Нийт хөрөнгө	35,325,937.5	35,834,642.0	508,704.5
Өр төлбөр	60,710,704.3	61,229,916.9	519,212.6
Эздийн өмч	(25,384,766.9)	(25,395,274.9)	(10,508.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	35,325,937.5	35,834,642.0	508,704.5

Тайлант онд бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данстуудын үлдэгдэлд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Бараа материалын дансны үлдэгдэл 50.2 сая төгрөг болж, тайлант онд Эрчим хүчний яамнаас ТЭЗҮ-ийн нэмэлт судалгааны ажлын зориулалтаар бараа материал хүлээн авсан нь нөлөөлж, 27.1 сая төгрөгөөр өссөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 566.7 сая төгрөг болж, тайлант онд Эрчим хүчний яамнаас 501.0 сая төгрөгийн багаж хэрэгсэл хүлээн авсан, элэгдлийн зардал байгуулсан нь нөлөөлж, 485.0 сая төгрөгөөр өссөн;
- Биет бус хөрөнгө 18,639.4 сая төгрөг болж, тайлант онд ирээдүйд баригдах усан цахилгаан станцын өртөгт орох ТЭЗҮ болон 48 нэр төрлийн 16,475.5 сая төгрөгийн судалгааны зардлыг бусад эргэлтийн бус хөрөнгөд ангилан бүртгэсэн нь нөлөөлж, 16,480.3 сая төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр 61,229.9 сая төгрөг болж, тайлант онд үнэ төлбөргүй буюу тусламжаар авсан хөрөнгийг НББОУС 20 "Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба засгийн газрын туслалцааны тодруулга" стандартын орлогын аргын дагуу хойшлогдсон орлогоор бүртгэсэн нь нөлөөлж, 519.2 сая төгрөгөөр өссөн;
- Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн тайлант үеийн үр дүнтэй холбоотойгоор өмнөх оноос 10.5 сая төгрөгөөр буурсан байна..

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2025 оны А/30 дугаар тушаалаар баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,262.6 сая төгрөгөөр, зардлыг 1,151.3 сая төгрөгөөр, 111.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 52.5 сая төгрөгийг төлөвлөснийг 2025 оны 8-р сарын 18-ны өдрийн компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Гүйцэтгэлээр Эрчим хүчний сайдын багцаас үйл ажиллагааны зардалд 770.3 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, 2.5 сая төгрөгийн түрээсийн орлого, 2.8 сая төгрөгийн хүүгийн орлого, нийт 776.6 сая төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлж, үйл ажиллагаанд 786.8 сая төгрөгийг зарцуулж, 10.2 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай тайлагнасан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 776.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 486.0 сая төгрөг буюу 38.5 хувиар тасарсан нь Эрчим хүчний яамнаас 2025 оны 4 дүгээр улирлын цалингийн зардлаас бусад зардлын санхүүжилтийг олгоогүйтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 786.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 364.5 сая төгрөг буюу 31.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Ерөнхий сайдын 2025 оны 01, 04, 05 дугаар албан даалгавар, Засгийн газрын 2025 оны 172 дугаар тогтоолын хүрээнд хийж буй гурван судалгааны ажлын санхүүжилтийг холбогдох яам хугацаанд нь олгоогүйтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитын менежер Г.Нандинцэцэг, туслах аудитор Ц.Мэндсайхан, Э. Хонгорзул, аудиторын туслах Ж.Отгонжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын тайлангийн нийт зардлын 1,875.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 18.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани нь батлагдсан зорилтот түвшний дагуу үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Тайлант онд 0.7 сая төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч, албан томилолтын зардал болон хурал зөвлөгөөний зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7-д “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин архи, согтууруулах ундаа худалдан авсан 0.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 26.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1. Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 харилцагчийн 47.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтаас 24.1 сая төгрөгийн үнэ бүхий 2 харилцагчийг мэдээлсэн, 23.8 сая төгрөгийн үнэ бүхий 2 харилцагчийн худалдан авалтыг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 1.5 сая төгрөгийн Starlink төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн нүүр таних төхөөрөмж, соронзон цоож худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, компанийн онцлогт нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компани өөрийн нөөц боломжийг ашиглан, төсвөөс зардал гаргахгүйгээр компанийн өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулан, дагаж мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай, албан томилолтын зардал нь төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалттай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэл тодорхойлон горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 47.0 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 60,622.5 сая төгрөгийн 2 алдааг залруулах зөвлөмж өгч, аудитын илрүүлэлтийг шалгагдагч этгээдэд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Аудитын дүнг жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,479.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 16,475.5 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2.4 сая төгрөгийн 2 зөвлөмж, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 01/24 дүгээр албан бичгээр, хэрэгжилтийн тайланг 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 01/71 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	2,369.9	2	2,369.9	100.0
Албан шаардлага	1	1,684.6	1	1,684.6	100.0
Хариуцлага тооцох	1	-	1	-	100.0
Нийт дүн	4	4,054.5	4	4,054.5	100.0

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Нийслэлийн татварын газарт 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/09 дүгээр албан бичгээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.5.12 дахь заалтад заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх ангилалд орох хүсэлт илгээсэн боловч уг хүсэлтийн хариу шийдвэрийг авч асуудлыг шийдвэрлээгүй байна;
- Хөгжлийн банкнаас 2013-2018 онд авсан зээлийн хуримтлагдсан өр төлбөрийн төлөх эх үүсвэрийг үе шаттайгаар улсын төсөвт батлуулж, шийдвэрлүүлэх Засгийн газрын 2025 оны 32 дугаар тогтоолын хэрэгжилт;
- Усан цахилгаан станцын авто зам болон цахилгаан дамжуулах агаарын шугамын газрын зарим хэсэг нь цэргийн анги, тариалангийн талбай, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хайгуулын талбайн газартай давхацсан асуудлыг арилгаж, бүртгэлийн залруулга хийх ажлын хүрээнд 117 нэгж талбарт үүссэн давхцалыг шийдвэрлэж, кадастрын зураглал, бүртгэл хийлгэн, Монгол Улсын газрын цахим бүртгэлийн системд бүртгүүлж, эзэмшил газрын талбайн өөрчлөлтийн захирамжийг гаргуулсан ажлын хэрэгжилт, санхүү бүртгэлд бүрэн тусгагдсан эсэх;
- Гэрээний хугацаа 2026 онд дуусах судалгааны ажлуудын гүйцэтгэл, үр дүн;
- Санхүүгийн бүртгэлд тусгагдсан 2 харилцагчийн 92.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа тул тайлант онд уг үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байсан.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 18,642.3 сая төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 18,642.3 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа

1. Бусад биет бус хөрөнгө дансанд "Биет бус хөрөнгө"-ийн шалгуур хангахгүй, ирээдүйд баригдах усан цахилгаан станцын өртөгт орох техник эзийн засгийн үндэслэл болон 2013-2024 онд хийсэн 48 нэр төрлийн 16,475.5 сая төгрөгийн судалгааны зардлыг бүртгэсэн нь НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ийн 16, 17-р параграф, НББОУС 38 "Биет бус хөрөнгө"-ийн 54-р параграф, "үнэн зөв байх" батламж мэдэгдэл;

2. Биет бус хөрөнгийн шалгуур хангаагүй, ашиглалтын хугацааг тодорхойлох боломжгүй хөрөнгөд хорогдуулга тооцон тайлант хугацааны зардлаар бүртгэсэн нь НББОУС 38 "Биет бус хөрөнгө"-ийн 107-р параграф, "хэмжилт" ба "үнэн зөв байх" батламж мэдэгдэл;

3. Тайлант хугацаанд Эрчим хүчний яамнаас хүлээлгэн өгсөн 14 нэр төрлийн 519.9 сая төгрөгийн хөрөнгийг бусад орлогоор бүртгэсэн нь НББОУС 20 "Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба засгийн газрын туслалцааны тодруулга"-ын 17-р параграф, "үнэн зөв байх" батламж мэдэгдэл;

4. Хүүгийн орлогоос суутгуулсан татварын зардлыг орлогын албан татварын зардлаар бус ерөнхий удирдлагын зардлын татвар хураамжийн дансанд бүртгэсэн нь НББОУС 12 "Орлогын албан татвар"-ын 12-р параграф, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Нийт илрүүлсэн 18,642.3 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Бусад биет бус хөрөнгө дансанд НББОУС 38 "Биет бус хөрөнгө"-ийн шалгуур хангахгүй, ирээдүйд баригдах усан цахилгаан станцын өртөгт орох ТЭЗҮ, түүнтэй холбоотой 2013-2024 онд хийсэн 48 нэр төрлийн судалгааны зардлыг бүртгэсэн.	1	16,475,455.7	-	-	1	16,475,455.7	1	16,475,455.7	-	-	-	-
2	Биет бус хөрөнгийн шалгуур хангаагүй, ашиглалтын хугацааг тодорхойлох боломжгүй хөрөнгөд хорогдуулга тооцон тайлант хугацааны зардлаар бүртгэсэн.	1	1,646,643.3	-	-	1	1,646,643.3	1	1,646,643.3	-	-	-	-
3	Тайлант хугацаанд Эрчим хүчний яамнаас хүлээлгэн өгсөн 14 нэр төрлийн хөрөнгийг НББОУС 20-ын дагуу бүртгээгүй.	1	519,910.9	-	-	1	519,910.9	1	519,910.9	-	-	-	-
4	Хүүгийн орлогоос суутгуулсан татварын зардлыг орлогын албан татварын зардлаар бус ерөнхий удирдлагын зардлын татвар хураамжийн дансанд бүртгэсэн.	1	284.3	-	-	1	284.3	1	284.3	-	-	-	-
	Дүн	4	18,642,294.1	-	-	4	18,642,294.1	4	18,642,294.1	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 харилцагчийн 47.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтаас 24.1 сая төгрөгийн үнэ бүхий 2 харилцагчийг мэдээлсэн, 23.8 сая төгрөгийн үнэ бүхий 2 харилцагчийн худалдан авалтыг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй байна.	1	23,774.7	-	-	1	23,774.7	-	-
Дүн	1	23,774.7	-	-	1	23,774.7	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Компанийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Архи, согтууруулах ундаа худалдан авч албан томилолтын зардал болон хурал зөвлөгөөний зардалд бүртгэсэн.	1	741.6	1	741.6	-	-	-	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 1.5 сая төгрөгийн өртөгтэй Starlink төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн өртөгтэй нүүр таних төхөөрөмж соронзон цоож худалдан авсан байна.	1	2,830.5	-	-	1	2,830.5	-	-
Дүн	3	3,572.1	1	741.6	1	2,830.5	1	-
Нийт дүн	4	27,346.8	1	741.6	2	26,605.2	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 143/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/92/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэргээ. Үүнд:

Тайлант онд 741,600.00 (Долоон зуун дөчин нэгэн мянга зургаан зуун) төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч, албан томилолтын зардал болон хурал зөвлөгөөний зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7-д "Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин архи, согтууруулах ундаа худалдан авсан 741,600.00 (Долоон зуун дөчин нэгэн мянга зургаан зуун) төгрөгийг Эдийн засагч С.Батсайханаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор гаргаж, нотлох баримтын хамт Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал (М.Баттулга), нягтлан бодогч (Г.Эрдэнэцэцэг)-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 634/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/92/МА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд 23,774,700.00 (Хорин гурван сая долоон зуун далан дөрвөн мянга долоон зуун) төгрөгийн 2 харилцагчийн худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийг бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал (М.Баттулга), Нягтлан бодогч (Г.Эрдэнэцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 635/A0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/92/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 1,525,000.00 (Нэг сая таван зуун хорин таван мянган) төгрөгийн Starlink төхөөрөмж, 1,305,480.00 (Нэг сая гурван зуун таван мянга дөрвөн зуун наян) төгрөгийн нүүр таних төхөөрөмж, соронзон цоож худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал (М.Баттулга), Нягтлан бодогч (Г.Эрдэнэцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Э.МӨНХТОГТОХ